



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-11
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12-44

1. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	12-14
2. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	14-34
3. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	34-40
4. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	40-41
5. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүн 2025.11.07-ны өдөр өргөн мэдүүлсэн/	41-44

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 13 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Ундраа;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Б.Батцэцэг, Ж.Бат-Эрдэнэ, С.Замира, У.Отгонбаяр, Р.Сэддорж;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар.

**Нэг. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, мөн газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, Шинжлэх ухааны академийн Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч, шинжлэх ухааны доктор, академич Ц.Цэрэндорж, мөн академийн Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн Газар зүйн мэдээллийн систем, зураг зүйн салбарын дарга Ц.Наранцацрал, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, доктор Н.Нарангэрэл, Монгол Улсын гавьяат барилгачин, зөвлөх инженер Д.Оюунчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн хэлтсийн шинжээч Б.Цагаанцэцэг, ахлах мэргэжилтэн Б.Баяр-Эрдэнэ, М.Алтанхорол, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Н.Ууганбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батбаяр, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чулуунчимэг, Ерөнхий нягтлан бодогч Д.Оюун-Эрдэнэ, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Цаг уурын газрын дарга Э.Баттулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Болорсүх, мөн газрын ерөнхий санхүүч Ц.Амгалан, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Х.Алтангэрэл, мөн газрын Санхүүгийн газрын ахлах шинжээч С.Мягмаржав, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Хөдөө аж ахуйн корпораци төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал Б.Цогтсаран, мөн компанийн ерөнхий нягтлан бодогч Б.Сосорбарам, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Д.Энхдалай, Б.Долгорсүрэн, В.Эрдэнэцогт, С.Нацагдорж, ахлах аудитор Ж.Бүжинханд, П.Батцэцэг, Б.Ариунжаргал, С.Бат-Эрдэнэ, Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер У.Оюунхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баярсайхан, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Гүйцэтгэлийн тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай,

Д.Жаргалсайхан, П.Батчимэг нарын тавьсан асуултад Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хэлэлцэх асуудлын дарааллын 3 дугаар асуудал буюу “Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хаалттай горимоор хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Бейсен Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 11 цаг 33 минутад хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Байнгын хорооны хаалттай хуралдаан 18 минут үргэлжилж, 11 цаг 50 минутаас нээлттэй горимд шилжив.

Гурав.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн

мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Х.Мөнхзул, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын ахлах шинжээч Ц.Мөнхбат, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Нарангарвуу, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн ахлах шинжээч Х.Номин, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хуулийн зөвлөх Б.Номун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-т нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэний дагуу санал хураалт явуулав.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн талаар:

Б.Бейсен: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, С.Ганбаатар, П.Наранбаяр, С.Одонтуяа, П.Сайнзориг, Ч.Ундром, С.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг, 4.1.3 дахь заалтын “нэг ижил” гэснийг, 4.1.5 дахь заалтын “, болон сайн дурын санаачилгыг хэрэгжүүлэх” гэснийг, 4.1.12 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу” гэснийг, 4.1.13 дахь заалтыг, 4.1.15 дахь заалтын “зорилгоор ашигладаг” гэснийг, 4.1.16 дахь заалтыг, 4.1.21 дэх заалтын “замаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах бодлого,” гэснийг, 4.1.25, 4.1.27 дахь заалтыг, 4.1.30 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд” гэснийг, мөн заалтын “тохируулга хийж” гэснийг тус тус хасаж, 4.1.3 дахь заалтын “шингээлт эсхүл” гэснийг “шингээх үйл ажиллагаанаас үүссэн” гэж, 4.1.4 дэх заалтын “тогтвортой” гэснийг “арга хэмжээ,” гэж, 4.1.6 дахь заалтын “зах зээлийн тогтолцоог” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.14 дэх заалтын “шингээсэн” гэснийг “хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлсэн” гэж, 4.1.15 дахь заалтын “шаардлагаас” гэснийг “үүргээс” гэж, 4.1.28 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж тус тус өөрчилж, 4.1.6 дахь заалтын “худалдах,” гэсний дараа “арилжих, дүйцүүлэх,” гэж, 4.1.20 дахь заалтын “үйлдвэрлэл,” гэсний дараа “үйлчилгээ,” гэж, 4.1.28 дахь заалтын “зохицох” гэсний дараа “, даван туулах” гэж, 4.1.30 дахь

заалтын “нэмж” гэсний дараа “, эсхүл хасаж” гэж, 4.1.32 дахь заалтын “бусад хийг” гэсний өмнө “олон улсын гэрээ, стандартаар хүлэмжийн хий гэж хүлээн зөвшөөрөгдсөн” гэж, 4.1.33 дахь заалтын “ой,” гэсний дараа “бэлчээр,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 4
Бүгд: 19
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.8, 4.1.10, 4.1.11, 4.1.18, 4.1.19, 4.1.22, 4.1.24, 4.1.26, 4.1.31, 4.1.36, 4.1.37, 4.1.38, 4.1.39 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“даван туулах” гэж уур амьсгалын өөрчлөлт, аюулт үзэгдэл тулгарахад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтолцоо, үндсэн чиг үүрэг, өвөрмөц чанар, бүтцээ хадгалан хариу үйлдэл үзүүлэх, сэргээн зохион байгуулагдах, дасан зохицох чадавхыг;

4.1.7.“карбон кредит” гэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжтойгоор баталгаажсан, бүртгэгдсэн карбон нэгжийг;

4.1.8.“карбон нэгж” гэж сааруулалтын үр дүнг нэг тонн нүүрстөрөгчийн давхар ислийн тэнцэлд дүйцэх байдлаар илэрхийлсэн тооцооллын нэгжийг;

4.1.10.“ногоон таксономи” гэж байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн зорилтод хувь нэмэр оруулах эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг тодорхойлсон нэгдсэн шалгуур, ангиллыг;

4.1.11.“олон талт карбон зах зээл” гэж олон улсын гэрээ, шийдвэрийн хүрээнд төвлөрсөн зохицуулалтаар хэрэгжих, олон улсад шилжүүлэн тооцох, сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.18.“уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн агаар мандлын хийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс үүдэн уур амьсгалд урт хугацаанд гарч буй өөрчлөлтийг;

4.1.19.“уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий хүн амын бүлэг” гэж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, газар зүйн байршлын улмаас түүнд дасан зохицох, даван туулах чадавх хязгаарлагдмал хүн амын бүлгийг;

4.1.22.“уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл” гэж уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг өөрчлөлтийг;

4.1.24.“уур амьсгалын санхүүжилт” гэж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг;

4.1.26. “үндэсний карбон зах зээл” гэж үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд үүссэн карбон кредитийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах замаар зохицуулсан зах зээлийг;

4.1.31. “хоёр талт карбон зах зээл” гэж улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.36. “хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх” гэж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй тохиолдолд үүсэх байсан хүлэмжийн хийн ялгарлаас зайлсхийхэд чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.37. “хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах” гэж хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.38. “хүлэмжийн хийн ялгарлын тэнцэл” гэж тайлант хугацаанд үүссэн хүлэмжийн хийн нийт ялгарлаас бууруулалт, урьдчилан сэргийлсэн ялгарал болон шингээлтийг хасан гарах цэвэр дүнг;

4.1.39. “хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнг батлагдсан аргачлалын дагуу хэмжих, үр дүнг тайлагнах, тайлагнасан мэдээллийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн этгээдээр шалгуулан баталгаажуулах үйл ажиллагааг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “хөтөлбөрийг тодорхойлсон” гэснийг “хөтөлбөрт зориулсан” гэж, 7.1.9 дэх заалтын “санхүүжилтийн орлогын урсгалыг” гэснийг “санхүүжилтийг” гэж, 7.1.10 дахь заалтын “ажиллагааг удирдах зохицуулах” гэснийг “ажиллагааны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “энэ хуульд заасан асуудлаар” гэснийг, 7.1.8 дахь заалтын “хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээлтийн үр дүнг тооцох, баталгаажуулах, тайлагнахтай холбоотой” гэснийг, 7.1.9 дэх заалтын “ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгал, үр ашиг, зарцуулалтыг бүртгэх, хянах, тайлагнах, цаашдын төлөвлөлтийг хангах, олон улсын тайлагнал болон ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой” гэснийг, 7.1.10 дахь заалтын “энэ хуулийн 4.1.27-д заасан” гэснийг, 7.1.11 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.1.1, 7.1.2 дахь заалт болгох:

“7.1.1.уур амьсгалын өөрчлөлтийн төлөвлөлт, хэрэгжилтийн салбар хоорондын уялдааг хангах зорилгоор Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хороог байгуулж, ажиллуулах;

7.1.2. Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны санал, зөвлөмжийг үндэслэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “уур амьсгалын” гэсний дараа “өөрчлөлтийн” гэж нэмж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн хүрээнд” гэснийг “ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн” гэж, 11.1.2 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, мөн заалтын “хариуцсан зохих байгууллагад” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар” гэж, 11.1.3 дахь заалтын “удирдах” гэснийг “удирдлага, зохион байгуулалтаар хангах” гэж тус тус өөрчилж, 11.1.6 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэн” гэснийг, 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, 11.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.9. сааруулалтын үр дүнгийн урт хугацааны хадгалалт алдагдах, хэтрүүлэн тооцож шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнгийн тодорхой хувийг эрсдэлийн санд нөөцлөн, энэ хуулийн 7.1.7-д заасан журмын дагуу буцаан олгох, удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 4
Бүгд: 19
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгана.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 4
Бүгд: 19
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 16.1, 16.4, 16.6 дахь хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1. Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 12.1, 12.2-т заасан үнэлгээний үр дүнд үндэслэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг Үндэсний

тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

16.4.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 4.1.19, 4.1.20-д заасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар, хүн амын бүлгийн дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

16.6.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	4
Бүгд:	19

78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Х.Мөнхзул, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын ахлах шинжээч Ц.Мөнхбат, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Нарангарвуу, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн ахлах шинжээч Х.Номин, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хуулийн зөвлөх Б.Номун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайг дэмжсэнээр тооцож, 73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтооын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүн 2025.11.07-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ, хязгаар Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 2 цаг 03 минут үргэлжилж, 29 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 65.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 цаг 13 минут

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 51.7 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгосон тойрог нэрээр танилцуулъя. Очирбаатарын Амгаланбаатар ирсэн байна. Мөнгөнцэцэгийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Тогтоомлын Мөнхсайхан гишүүн өссөн байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна. Сүрэнжав Лүндэг гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна.

Хэлэлцэх асуудал.

1.Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2026 оны 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг.

2.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2026 оны 06 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

3.Байнгын хорооны тогтоолын төсөлд шинжээч томилох тухай.

4.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2026 оны 05 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

5.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлэг.

6.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн Баатархүү нарын 35 гишүүн, 2025 оны 11 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе.

Нэг. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

А.Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Д.Мөнхцэцэг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын Геодези зураг зүйн хэлтсийн мэргэжилтэн, Н.Нарангэрэл Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга, доктор, Ц.Наранцацрал ШУА-ийн Газар зүйн геокологийн хүрээлэнгийн Газар зүйн мэдээллийн систем, зураг зүйн салбарын дарга, О.Самбуудорж ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, Очирцэнд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн харьцуулсан хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан, Д.Оюунчимэг Монгол Улсын гавьяат барилгачин зөвлөх инженер.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулна. Уянгаа гишүүнд микрофон өгье.

Б.Уянга: Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооноос гаргасан тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдэлж Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөн, бүтэц найруулга, латин хөрвүүлэгт холбогдох хууль зүйн техникийн засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгын төслийг та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Б.Бейсен: Уянгаа гишүүнд баярлалаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгаа чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Ажлын хэсэгт баярлалаа.

10.20 цаг

Дараагийн хэлэлцэх асуудалд орёё.

Хоёр.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Дараагийн ажлын хэсгээ оруулаарай.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгээ оруулаарай.

Сандагийн Очир сайд танилцуулна. Ерөнхий аудиторoo дуудаарай. Мэндсайхан сайд Рио Тинтогийн хуралтай байгаа учраас хожигдож байгаад ирэх байх. Тэгээд Сандаг-Очир сайд танилцуулж байна гэсэн. Сандаг-Очир сайдыг дуудаарай.

Ажлын хэсгээ танилцуулж байя. Цэндийн Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайд, Цагаанхүүгийн Идэрбат ХХААХҮ-ийн сайд, Бат-Ирээдүйгийн Анар Сангийн яамны ТНБД, Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД, Жамбалсүрэнгийн Чулуунчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганхуягийн Болорсүх ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Цэндгомбын Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Доржийн Оюун-Эрдэнэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ерөнхий нягтлан бодогч, Бямбасүрэнгийн Оюунсанаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ойн газрын дарга, Оюунсанаа ирсэн үү? Байна уу? Зинамядрын Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Усны газрын дарга, Эрхэмбаярын Баттулга, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Цаг уурын газрын дарга, Цэрэнпунцагийн Амгалан ХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Ерөнхий санхүүч, Батжаргалын Цогтсаран хөдөө аж ахуйн корпорац, төрийн өмчит улсын компанийн захирал, Бандийн Сосорбарам Хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит хариуцлагатай ХК-ийн ерөнхий нягтлан

бодогч, Хөхөөгийн Алтангэрэл ХХААХҮЯ Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Сангирагчаагийн Мягмаржав Мал эмнэлгийн ерөнхий газрын Санхүүгийн газрын ахлах шинжээч, Ядамсүрэнгийн Эрдэнэсайхан ХХААХҮЯ-ны ЖДҮ-ийн газрын дарга, Огнонгийн Хуягцогт Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Болдбаатарын Цагаанцэцэг Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч, Баясгалангийн Баяр-Эрдэнэ Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Мэндийн Алтанхорол Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Эрдэнэбилигийн Буянхишиг Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Ж.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Н.Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн.

Үндэсний аудитын газраас Магнайсүрэн дарга Монгол Улсын ерөнхий аудитор, З.Цэдэнжав Монгол Улсын ерөнхий аудиторов орлогч, Н.Цэвэлмаа Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Б.Баттуяа Нийслэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Баярсайхан Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Ч.Сэвэгдорж Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, П.Чанцалдулам Санхүүгийн аудитын газрын ахлах менежер, Д.Энхдалай Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Б.Долгорсүрэн Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, В.Эрдэнэцогт Санхүүгийн аудитын газрын аудитийн менежер, Ц.Нацагдорж Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, У.Оюунхүү Гүйцэтгэлийн аудитын газрын ахлах аудитор.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир сайдын микрофон өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын чуулганы 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлээр тэнцвэр тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2025 онд 30 их наяд 303.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.7 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.8 хувьд тус тус хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт

тэнцэл 1 их наяд 27.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ий 1.1 хувьтай тэнцэж байна аа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 145 байгууллага, 6 төсөл сан төрийн өмчийн 10 аж ахуйн нэгж, нийт 161 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно оо.

Тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 696.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч үүнээс урсгал зардалд 556.8 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 106.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна аа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд тус Байнгын хороонд харьяалагдах 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн 30 төсөл арга хэмжээнд 106.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 84.7 хувийн биелэлттэй байна аа.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Б.Бейсен: Сандаг-Очир сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. 6 номер.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Тус байнгын хороонд харьяалагдах 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 94 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 49 байгууллагад дүгнэлт гаргаж, 45 байгууллагыг аудитийн түүвэрт хамруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 43 байгууллагад өөрчлөлтгүй, 5 байгууллагад хязгаарлалттай, нэг байгууллагад сөрөг дүгнэлтийг тус тус өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 31.8 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.4 тэрбум төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож 12.8 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 53 албан шаардлага хүргүүлж, 19.8 тэрбум төгрөгийн зөрчилд 70 зөвлөмж өгч 0.01 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага

тооцуулах 3 албан шаардлага хүргүүлж, 1.6 тэрбум төгрөгийн 3 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Өмнөх оны аудитаар алдаа зөрчлийг арилгах 8.9 тэрбум төгрөгийн 5 албан шаардлага, хариуцлага тооцуулах нэг албан шаардлага хүргүүлснээс хэрэгжилт 80 хувьтай байна аа.

Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 64.8 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 48 төсөл арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөснөөс 16.8 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 27 төсөл арга хэмжээ буюу 56.2 хувь нь тухайн онд бүрэн хэрэгжсэн байна.

2.ХХААХҮ-ийн сайд

ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 65 байгууллагын санхүүгийн тайланд тайлан нэгтгэснээс 53 байгууллагад дүгнэлт гаргаж 12 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 35 байгууллагад өөрчлөлтгүй, 18 байгууллагад хязгаарлалттай дүгнэлтийг тус тус өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 215.4 тэрбум төгрөгийн 200 зөрчил илэрснээс 0.07 тэрбум төгрөгийн 31 төлбөрийн акт тогтоож, 109.4 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 87 албан шаардлага хүргүүлж, 18.9 тэрбум төгрөгийн зөрчилд 80 зөвлөмж өгч, 87 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн байна аа.

Өмнөх оны аудитаар 80.7 тэрбум төгрөгийн 2 албан шаардлага, 6 зөвлөмж өгснөөс биелэлт 57.6 хувьтай байна. ХХААХҮ-ийн сайдын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 51.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 44 төсөл арга хэмжээ 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөснөөс 21.4 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 37 төсөл арга хэмжээ буюу 84.1 хувь нь тухайн онд бүрэн хэрэгжсэн байна аа.

Дээр дурдсан аудитын дүгнэлтээс үндэслэн дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна гэж үзлээ. Үүнд.

1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн төслийн саналыг боловсруулахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлж тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, түүнд зарцуулах төсвийг үнэн зөв төлөвлөж бодитой тайлагнах,

2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх, үр дүнг үнэлэх үе шат бүрд төсвийн ерөнхийлөн захирагч болон оролцогч байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлагыг сайжруулах.

3.Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өмнөх онуудад хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний үр дүнг дүгнээгүй, дуусаагүй байх асуудал давтагдан гарч байхад ижил төстэй арга хэмжээг хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлж гүйцэтгэсэн байгаад хяналт тавьж үр дүнг үнэлж хэвших.

4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн байдлын тайлан дахь бусад эргэлтийн хөрөнгө дансан дахь хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон ашиглалтад орсон хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, ажлын гүйцэтгэл санхүүжилтийг үе шат бүрээр бүртгээгүй зэрэг зөрчил илэрч байгаад дүн шинжилгээ хийж, эрх бүхий төрийн байгууллагад хандан асуудлыг шийдвэрлүүлэх.

5.Хөдөөгийн хөгжил төслийн Монголбанкнаас тогтоосон арилжааны банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан банканд байршиж байгаа 6.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлэх ажил удаашралтай байгаад анхаарал хандуулж бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авах.

6.Салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийн нэгжийн үйл ажиллагааг хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.

7.Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд анхаарч аудитын шийдвэрийн болон хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаа асуудалд дүн шинжилгээ хийж цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж төсөв санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч төсвийн тухай хуулийн 69 дүгээр заалтын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дотоод хяналтын тогтолцоогоо сайжруулах зэрэг асуудлыг чиглэл болгож байна. Танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Магнайсүрэн даргад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд Засгийн газрын 2025 онд санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх Сангийн сайдын найз залуу болон аудитын дүгнэлт, төсвийн ерөнхийлөн захирагчдаас холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Мандхай гишүүнээр тасаллаа. Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Нэгдүгээрт ерөнхий гол хөрөнгө оруулалттай холбоотой асуулт асууя. Энэ хөрөнгө оруулалтын зардал бараг 2.5 их наядаар тасарсан үзүүлэлттэй гарсан байна. Төлөвлөсөн хөрөнгө оруулалт 9.5 их наяд, гүйцэтгэл 7 их наядаар энэ бол бас асуудал гэж харж байгаа. Гол нь энэ төлөвлөсөн энэ хөрөнгө оруулалт яагаад тасарчхав? Аль салбар хамгийн их хоцрогдолтой гүйцэтгэлтэй гарав гэдэг асуулт байна. Энийг тэгэхдээ өшөө дахиж нарийвчилж тайлбарлаж өгнө үү. Энэ тендерийн асуудал байсан уу? Зураг төсөлтэй холбоотой юу? Газрын асуудал уу? Яг ямар асуудлаас ийм өндөр дүнтэй төсөв тасарчхав гэдэг асуултыг асууя.

Тэгээд энэ хэрэгжээгүй хөрөнгө оруулалт нь одоо энэ 2026 он гэхэд хэд нь дахин энэ санхүүжүүлэхээр тооцож оруулж ирж байгаа вэ? Энэ барилга байгууламжийн ажил 1.7 их наядаар тасарсан байна аа. Төлөвлөгөө дээр 6.8 их наяд мөртөө гүйцэтгэл дээр 5.1 гэж байгаа. Тэгэхээр энэ одоо яг дуусаагүй яг ямар ямар барилгууд үлдчихэв. Аль аль газар хаана үлдсэн бэ? Орон нутагт уу, нийслэлд үү гэдэг ийм нарийн задаргаатай нь танилцуулаад өгөөрэй.

ХАА-тай холбоотой нэг асуулт асууя аа. ХАА-н хүнсний салбар дээр энэ ашиг шимтэй тариалан МАА-н нутгийн газар нутгийн ашиглалт гэж байгаа. Энэ усалгаатай газар өрхийн аж ахуй, ААН-д шинээр нэвтрүүлсэн технологи, хүлэмжийн тоо, үр дүнгийн өсөлт ер нь ямар гарсан бэ? Бууралттай гарсан бол яг тодорхой шалтгааныг нь тодруулж өгнө үү. Мөн энэ хүнсний хувьсгал бодитой үр дүн өгсөн талаар одоо жишээлбэл хүнсний хувьсгалын хүрээнд импортын орцыг хэдэн төгрөгөөр бууруулсан бэ? Дотоодын үйлдвэрлэлийн өсөлт энэ 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг өөрийгөө хангах түвшин, яг хэдэн хувиар сайжирсныг тоо хэмжээгээр танилцуулаад өгнө үү.

Мөн цагаан алт хөдөлгөөн дээр ноос ноолуур, арьс шир боловсруулах хүчин чадал хэдэн хувиар нэмэгдэж яг хэдэн үйлдвэр шинэчлэгдэж, малчдын орлого хэдэн хувиар нэмэгдсэн бэ? Аль аль аймгуудаас энэ цагаан алтын хүрээнд түүхий эдийн гэрээ хийж нийлүүлэлт нэмэгдүүлж чадсан бэ гэдгийг асууя.

ЖДҮ-лэл хөнгөн үйлдвэр дээр дэмжих сангийн зарцуулалт 2025 оны төсөв дээр ЖДҮ-ийн сангаар хэдий хэмжээний зээлийг өнөөдрийн байдлаар олгоод хэдэн аж ахуйн хөнгөлөлттэй зээл батлан даалт авсан бэ? Тэдгээрийн дундаж зээлийн хэмжээ бүтэн төлсөн хувь нь ямар байсан, дампуурсан хувь зэрэг мэдээллүүд ер нь.

Б.Бейсен: Сангийн яамнаас хэн хариулах вэ? 8 номер. Гишүүд зэрэгцээд Малчны тухай хуулийн хэлэлцүүлэг явагдаж байгаа учраас ажлын хэсэг гэхэд манай гишүүд 2 хуваагдчихаад байна шүү.

Б.Анар: Сангийн яам Анар, Мандхай гишүүний асуултад хариулъя.

Таны хэлж байгаа 2.2 гээд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэл гараагүй гээд. Энэ нөгөө орон нутаг улсын төсөв нийлээд нэгдсэн төсвийнхөөрөө гарч байгаа тоо. Яг улсын төсвийн хөрөнгө оруулалт бол нийтдээ 779 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бол гүйцэтгэл дутуу гарсан. Үүний 286 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бол нөгөө он дамжиж байсан санхүүжилт байсан учраас энэ оны хөрөнгө оруулалтаасаа санхүүжүүлсэн.

Өнгөрсөн онд эдгээр төслүүдийг орлогын гүйцэтгэлтэй холбоотойгоор гүйцэтгэл нь ирсэн ч гэсэн санхүүжүүлж чадаагүй дүн нь ерөөсөө 286 тэрбум төгрөгийн л санхүүжилт байсан. Тэгэхээр үлдсэн нөгөө 500 гаруй тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүд нь ондоо багтааж хүсэлт нь Сангийн яаман дээр ирээгүй гэсэн үг. Тэгэхээр нөгөө ажлын гүйцэтгэлтэйгээ уялдаад өөрсдөө угаасаа гүйцэтгэл муу байсан учраас санхүүжилтээ авъя гэдэг хүсэлт яаман дээр ирээгүй. Өөрөө хэмнэлт болсон. 276 тэрбум төгрөг нь бол гүйцэтгэлээ авъя гээд хүсэлт ирсэн боловч боловч оны эцэст үүссэн байсан орлогын нөхцөл байдалтай холбоотойгоор санхүүжилтийг нь гаргаж чадаагүй.

Гэхдээ эдгээр төслүүд нь энэ онд санхүүжих байсан дүнгээсээ санхүүжилтээ аваад явж байгаа. Түрүүний хэмнэлт болчихсон гэрээ байгуулагдсан 500 гаруй тэрбум төгрөгийн хэмнэлт яах вэ гэж асууж байна. Энэ бол 2027 оны төсөв дээр гүйцэтгэлтэй нь уялдуулаад төсөв дээрээ тусгах арга хэмжээ аваад явах ийм шаардлага байгаа.

Нэмээд нөгөө аль төсвийн ерөнхийлөн захирагч хамгийн муу гүйцэтгэлтэй байсан бэ гэж асуусан. Яг төсвийн ерөнхийлөн захирагчаар аваад үзэх юм бол Зам,

тээврийн сайд бол хамгийн том дүнгээр гүйцэтгэл гарч чадаагүй. 250 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт гараагүй байна.

Дараагийнх нь Хот байгуулалт орон сууцжуулалтын сайд 119 тэрбум төгрөг, Боловсролын сайд 104.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл дутуу гарсан. Бусдууд нь бага бага дүнтэй бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр гүйцэтгэл дутуу гарсан байна.

Б.Бейсен: Болорчулуун дарга хариулах уу? 9 номерт суучих юм уу. 9 нөмөр микрофон.

Ц.Болорчулуун: ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Мандхай гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн жил ер нь газар тариалангийн салбарт нийтдээ 406 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 508 ААН 1447 иргэнд олгосон. Тариалангийн талбай бол 83.1 мянган гагаар нэмэгдсэн. Хүлэмжийн талбай нийтдээ зуны хүлэмж 120 га, өвлийн хүлэмж 40 га болж 34.5 гагаар хүлэмжийн талбай нэмэгдсэн байгаа. Үтрэмийн багтаамж бол 67 мянган тонноор нэмэгдсэн зоорины багтаамж 50 мянган тонноор нэмэгдсэн ийм үзүүлэлттэй байна.

Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд.

Б.Бейсен: 9 номерын микрофон.

Ц.Болорчулуун: Цагаан алт хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд аваад үзэх юм бол өнгөрсөн жилийн түвшинд 6 мянган тонн ноолуурыг үндэсний үйлдвэрүүд бэлтгэсэн. Мөн 20 мянган тонн ноосыг дотоодын үндэсний үйлдвэрүүдэд бэлтгэсэн байгаа.

1.2 сая ширхэг бодын арьс, 0.5 сая ширхэг богийн арьсыг үндэсний үйлдвэрүүдэд авч үйлдвэрлэлд нэвтрүүлж байна аа.

Түүнчлэн ээрэх хүчин чадал 400 тонноор нэмэгдэж, 2978 тоннд хүрсэн. Сүлжих үйлдвэрийн, сүлжих хүчин чадал 200 мянган ширхгээр нэмэгдэж, 5298 мянган ширхэгт хүрсэн ийм үзүүлэлттэй байна аа.

Б.Бейсен: Тэр ЖДҮ-ийн талаар Эрдэнэсайхан дарга байна уу? 9 номерт сууж байгаад танилцуулчхаарай.

Я.Эрдэнэсайхан: Мандхай гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн жил ер нь сүүлийн жилүүдэд улсын төсөв дээрээс мөнгө төгрөг тавиагүй учраас зээлийн эргэн төлөлтөөсөө зээл олгоод явж байгаа. Ингээд эх үүсвэрийг бол улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, зээлийн эргэн төлөлт гэсэн энэ эх үүсвэрээс бүрдүүлэхээр хуульчилсан байдаг. Энэ хүрээндээ орон нутгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд аймгуудад 3, 4 жил орон нутгийн төсөв дээрээ төсөв мөнгө хуваарилаарай.

Ингэсэн тохиолдолд бол тухайн аймагт нь ЖДҮХС-аас нэмж хөрөнгө хуваарилаад ингээд зээлийг орон нутгийн сонгон шалгаруулалтыг хийгээд явж байгаа.

Тайлант хугацаанд бол 1210 зээлдэгч хүсэлт ирүүлсэн 170 тэрбум төгрөгийн. Үүнд бол 324 ЖДҮ эрхлэгчид 47.8 тэрбум төгрөгийн зээл олгосон байна аа.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Би нөгөө үр дүнгээ ерөөсөө л нэг сайн хариултаа авч чадахгүй байгаад байна л даа. Одоо жишээлбэл хүнсний хувьсгал гэхэд 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр бид нар дотооддоо 100 хувь хангах гэж байгаа. Үндсэн хөдөлгөөн маань ингээд ерөнхийдөө 1.2 их наяд төгрөгийн зарцуулалттай дуусаж байгаа. Тэгээд өнөөдрийн түвшинд яг одоо зах зээл дээр яг эндээс хэдэн нэр төрлийн бүтээгдэхүүн яг үндсэндээ Монгол Улс өөрийгөө хангах түвшинд хэдэн хувиар сайжраад тоо хэмжээгээрээ надад нэг үр дүнг нь хэлээд өгөөч. Цагаалт ч гэсэн ялгаа байхгүй.

Одоо яг би шууд үйлдвэрлэлд зээл олгосон байж болно. Гэхдээ энэ чинь түүхий эдээ малчдаас авч байгаа. Малчдын хэдэн хувь нь одоо яг гэрээлээд өнөөдөр ашиг орлого нь нэмэгдсэн юм бэ гэдэг ийм бодитой хариултыг хэлж өгөөч ээ.

Сангийн яамнаас би юм асуух гэсэн юм. Одоо ингээд энэ алдагдсан боломж үүсээд байна. 200 жишээлбэл уул уурхайн салбар 250 тэрбум төгрөг Боловсролын яам.

Б.Бейсен: Мандхай гишүүнд нэг минут олгоё.

М.Мандхай: Тэгэхээр Сангийн яамнаас би эсвэл Эдийн засаг хөгжлийн яам хариулдаг юм уу? Одоо энэ алдагдсан боломж яг ямар эрсдэл үүсэх юм бэ? Энэ мөнгө зарцуулагдаагүй, хугацаандаа хэрэгжээгүй том төслүүд эдийн засгийн өсөлт гэж төлөвлөгдсөн байгаа. Цаана нь энэ орон нутгийн хөгжил ажлын байр гээд маш олон асуудлууд байгаа. Магадгүй одоо ашигт малтмалын тэр олборлолт худалдаанаас нь төсөвт орох орлого буурсан ч гэдэг юм уу энэний үр дүнг ер нь юу гэж хэмжиж байгаа юм. Одоо ингээд олон яамдууд төлөвлөхөөд төлөв төлөөгүй тэгээд төлөвлө зарцуулагдаагүй байгаа шалтгаан нь ямар уч учир шалтгаан байгаа юм бэ гэдэг нэг ийм үр дүнд суурилсан нэг ийм бодитой хариулт авч болох уу?

Б.Бейсен: 9 номер Болорчулуун дарга эхлээд хариулъя.

Ц.Болорчулуун: Мандхай гишүүний асуултад нэмэлт хариулт өгье өө.

Ер нь хүнсний хувьсгал хөтөлбөр хэрэгжээд ингээд сүүлийн жил ингээд дуусаж байгаа. Ерөнхийдөө хөтөлбөрийн хэрэгжилтийг ерөнхий дүнгээр нь аваад үзэх юм бол 1.2 их наядын зээлийг энэ МАА газар тариалан хүнсний гэсэн 3 салбарт олгосон. Үүний үр дүнд 53 хүнсний үйлдвэр бол шинээр ашиглалтад орсон. Хүнсний мянга гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн бол бас зах зээлд нэвтэрсэн ийм ерөнхий үзүүлэлттэй байгаа. Дэвшүүлсэн гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээс өндөгний хэрэглээг бид нар 80 хувьд хүргэж байсан. Ингээд 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээрээ энэ танилцуулга байна. Би танд энийг танд энэ юугаар нь явуулъя тэгээд энэ дээр тодорхой үр дүнд гарсан бид нар цөцгийн тос, дээрээс нь тахианы мах гээд ингээд ургамлын тос гээд 100 хувийн импортын.

Б.Бейсен: 9 номер гүйцээж хариулъя.

Ц.Болорчулуун: Нэр төрлөөрөө байна. Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, лууван, байцай, шар манжин, сонгино, саримс гээд ингээд 19 нэр төрлөөрөө анхны 2022 оны хөтөлбөр хэрэгжих үеийн суурь түвшнийг хүрсэн түвшинтэйгээ энэ дээр ингээд хүснэгтээр гаргачихсан би тан руу энийг явуулчихъя. Та энэ дээрээс дэлгэрэнгүй танилцах боломжтой байх гэж харж байна. Ингээд энэнэний цаана ерөөсөө хүнсний боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадал нэмэгдээд үйлдвэрлэл нэмэгдэж байна гэдэг бол анхан шатын түүхий эд бэлтгэлийн буюу малчид тариаланчдын орлого нэмэгдэж байгаа л асуудал. Газар тариалангийн салбараас түүхий эдээ ханган нийлүүлэлтийг бэлтгэж байгаа. Ингэж байж хүнсний үйлдвэрүүдийн хүчин чадал үйлдвэрлэх хэмжээ нэмэгдэж байна.

Нөгөө талдаа МАА-н салбараас малчдын үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэж байж энэ боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадал нэмэгдэж байгаа. Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд аваад үзэх юм бол өнгөрсөн жил гэхэд бид нар энэ 0.5 сая ширхэг.

Б.Бейсен: Сангийн яам 8 номер.

Б.Анар: Мандхай гишүүний асуултад хариулъя.

2025 оны төсвийн хувьд яг улсын төсвөө аваад үзэх юм бол нийтдээ урсгал зардал дээрээс бол 1.2 их наяд орчим, хөрөнгийн зардал түрүүн хэлсэн 947, яг хөрөнгө оруулалтын зардал 770 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт гарч чадаагүй. Урсгал санхүүжилтийн хувьд бол яг хаанаас хэмнэгдсэн бэ гэхээр энэ бараа ажил үйлчилгээний зардал, татаас, урсгал зардал шилжүүлэхтэй холбоотой зарим зардлуудыг бол нөгөө орлогын гүйцэтгэлтэй холбоотой яалт ч үгүй хэмнэлтийн горимд шилжсэн. Энэ үүднээсээ урсгал зардлуудын зарим санхүүжилтүүдийг санхүүжүүлж чадаагүй ээ. Энэ бол нийтдээ 6 мянга гаруй төсөвт байгууллагууд төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр бол энэ төсвийн орлогын гүйцэтгэлтэй холбоотойгоор ийм зайлшгүй ийм арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байгаа.

Нөгөө талдаа та хөрөнгийн зардал гараагүйгээс болоод ямар хөрөнгө оруулалтын боломж олдсон талаар асууж байна. Нийгмийн төслүүд.

Б.Бейсен: 8 номер гүйцээж хариулъя.

Б.Анар: Хөрөнгө оруулалтын зардал дээр гүйцэтгэгч ААН-үүд нь нэгд өөрсдөө цаг хугацаанд нь барилга байгууламж авсан ажлаа ашиглалтад оруулахгүй байх нэг ийм асуудал байна. Сургууль, цэцэрлэг, зам гээд. Эдгээр ажлууд өөрөө цаг хугацаандаа ашиглалтад орохгүй байснаар ямар алдагдсан боломж үүсэж байна вэ гэхээр тухайн төрийн үйлчилгээ цаг тухайдаа нэгд хүрэх боломжгүй болж байгаа юм.

Хоёрт нөгөө эдийн засгийн үр өгөөж талаасаа энэ нь цаг хугацаа явах тусам өртөг нь улам өсөж байдаг. Тэгээд нөгөө магадалшгүй ажлын зардал төсөвт өртгийн нэмэгдэл гээд ингээд төсөв дээр нэмэлт зардлууд орж ирээд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ нь аягүй олон талтай байгаа. Нэгд нөгөө тендер зарлахаас өмнө бэлтгэл ажил нь хангалттай бэлдээгүй төслүүд байна. Тухайлах юм бол газрын асуудал бол нийслэлийн хөрөнгө оруулалтаар аягүй их яригддаг. Нөгөө талдаа.

Б.Бейсен: 8 номер гүйцээж хариулъя.

Нөгөө талдаа бол энэ гүйцэтгэгч ААН-үүдийн чадавхын асуудал байна. Шалгараад ажлаа цаг тухайд нь хийж чадахгүй байгаа. Чадавх чадамжтай холбоотой асуудал байна. Энийг бол мэдээж худалдан авах ажиллагаатай холбоотойгоор чадахгүй ААН-үүдийг бол цаашид энэ мэдээллийн бааз үүсгээд явах ажлыг Сангийн яамнаас зохион байгуулж байгаа. Тэгэхээр чадахгүй. Өмнө нь улсын төсвөөс ажил авч гүйцэтгээд тэрийгээ цаг тухайд нь хийж чадаагүй олон дахин давтан зөрчил гаргасан ААН-үүдийг энэ Тендерийн хуулийнхаа дагуу хар жагсаалт руу оруулах ийм аж ажлууд хийгдэж байна.

Дээрээс нь яагаад төсвийн энэ гүйцэтгэл бага гарсан юм бэ гэхээр бид хэд өмнө нь нэг барьцаа дансанд гээд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хийгдээгүй зарим санхүүжилтүүдийг аваад үлдээдэг байсан. Тэгээд энэ нь өөрөө 3, 4 жил дамнаад сүүл рүүгээ бүүр ийм зах замбараагүй юм болоод байсан. Тэгээд энэ 2025 оны гүйцэтгэлээс авхуулаад бид нар барьцаа дансанд энэ гүйцэтгэгдээгүй амжаагүй хөрөнгө оруулалтуудыг авч үлдэхээ больсон.

Б.Бейсен: Ерөнхий аудитор сая алдагдсан боломж гээд яриад байна. Урсгал зардлыг хэмнэлтийн хуулиар хассан юм уу аль эсвэл төсвийн ерөнхийлөгч захирагч нарын хариуцлагагүй байдлаас төсөвт нөгөө ингээд зарцуулагдахгүй байж байгаа юм уу. Тэндээ энэ дүн шинжилгээгээ хийсэн үү? Тэр талаар мэдээлэл өгөөч 6 номер.

С.Магнайсүрэн: Бейсен гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн.

Урсгал зардалтай холбоотой энэ төсвийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн асуудлаар өмнө нь бид нар сэдвээр аудит хийж танилцуулж байсан. Энэ удаа бид нарын оруулж ирсэн аудитын тайлангийн хэмжээнд бол өнөөдөр гарсан зөрчлийн нэлээд нь энэ төрийн хэмнэлтийн хуультай холбогдож гарсан ийм зөрчлүүд байж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Төрийн хэмнэлтийн хууль бол тодорхой хугацаанд, тодорхой цаг хугацаанд гарсан боловч өнөөдөр үйлчилсэн хэвээр байгаа. Энд бол ер нь төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагч нарын тухайд маш тийм хатуу заалттай. Нэгэнт хууль дээр заагдсан учраас манайхан зөрчил давж ингэж аудитын шийдэл өгөөд ингээд явчихдаг. Энэ дээр бол бүх төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагч нарын хувьд бол бас санал шүүмжлэл, гомдол нэлээн ярьдаг ийм асуудал.

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя.

С.Магнайсүрэн: Бид нар энэ дээр ингээд энэ асуудлыг авч үзээч гэдэг байдлаар зүгээр тайлан дээрээ энэнтэй холбоотой байна. Энэ дээр зөрчлийн энэ нөгөө өндөр байгаа шалтгаан гэж нэг хэлсэн.

Хоёрдугаарт нь бол бид нар одоо тодорхой 8, 9 сэдвээр судалгаа хийсэн. Энэ удаагийн аудитын явцад энэ дотор бол хэмнэж болох зардлууд урсгал зардал дотор судалгаа хийсэн. Тухайлах юм бол төсвийн захирагч нарын хүрээнд олон хурал зөвлөгөөнүүд зохион байгуулж байна. Гадаад явж байгаа зардлууд байж байна. Маш олон төсвийн захирагч нар өөрийнхөө төсвийн хүрээнд цахим буюу ийм программ хангамжууд хоорондоо холбоогүй ийм программ хангамжууд олноор яаж байна. Тэгээд одоо бусад 8 төрлийн судалгаа хийгээд бид нар энэ дээрээ дүгнээд тайлагнасан байж байгаа. Ийм зардлуудыг хэмнэж болох бололцоотой байна. Заримыг нь нэгдсэн байдлаар Цахим хөгжлийн яам гэдэг юм уу ингээд бодлогоор

зохион байгуулж энэ зардал хэмнэх бололцоотой байна гэдэг талаар бид нар энэ саналаа оруулж байж тайлагнасан байж байгаа.

Б.Бейсен: Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Энэ Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг бид нар хэлэлцэж байна. Тэгээд үндсэндээ ямар хөрөнгөөр ямар үр дүнд хүрэв ээ? Цаашдаа энэ 2026 он, бусад онууд дээр яаж ажиллах вэ л гэсэн л арга хэлбэр л дээ. Тэгээд үндсэндээ ингээд хараад сууж байхад л нэг ийм л юм байна л даа. Нийт төсвийн урсгал зардлын 73.4 хувийг нийт зарлагын урсгал зардлын 73.4 хувийг эзэлж байсан. 4 хувиар нэмэгдчихээд байгаа юм. Ингээд 77 хувь болчихоод байгаа юм. Тэгээд энэ байж болох юм уу? Улсын төсөв чинь хууль байтал яахаараа ингээд 4 хувиар ингээд өөрчлөгдөөд байдаг юм бэ? Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол энэ зөвлөмж дүгнэлтдээ оруулаагүй л байна л даа. Энэ тийм ноцтой зөрчил биш үү?

Би ноцтой зөрчил гэж хараад байна л даа. Бид нар нэг хууль батлаад байдаг. Тэгэхдээ дотор нь ингээд нийт зардлаа ингээд л тал тийш нь шилжүүлээд л ингээд ингэж болох юм уу? Нэг дэх асуулт. Дараагийнх нь энэ ААНОАТ 2026 оны төлөвлөгөөнд бол ингээд баахан л төлөвлөгөө баталсан л даа бид нар. Гэтэл урьдчилаад 2025 он дээр авчхаж байгаа юм. 2025 он дээр авчихаар чинь 2026 оны төсөв тасарна гэсэн үг үү? Хэдэн төгрөг урьдчилаад авчихсан юм? 2026 онд төлөх байсан татварыг 2025 онд авчхаад байна шүү дээ. Энэ дээр нэг тайлбар хэлээч? Энийг яа яаж тооцож байгаа юм. Өнөөдөр болвол маргааш хамаагүй гэж бодож байгаа юм уу гэсэн байдлаар асууж байна.

Дараа нь энэ аудитаас асуумаар байна л даа. Энэ манай боловсролын сайд аргаа ядсан л хүний үг ярьж байна лээ л дээ. Үнэхээр энэ тендер аваад тэр тендерээ жил ирэх тусам үнийг нь би төсвөө нэмүүлдэг. Тэгээд тэр зураг төсөв нь ч гэсэн ингээд дутуу батлагдчихсан байдаг. Тэгэхээр энэ ерөөсөө мафийн сүлжээ болсон байна аа. Зураг хийхдээ ч тэр, батлахдаа ч гэсэн тэр. Тендерт орохдоо ч гэсэн тэр. Дараа нь аудит хийгээд тэр үнийг нэмдэг ч гэсэн тэр. Бүр ингээд 16 компани ч гэлүү ингээд ийм компаниуд байна энийг хар жагсаалтад оруулна зарлана гэж байгаа юм. Энийг манай аудитынхан мэдэж байна уу? Сангийн яам мэдэж байна уу? Бид нар үнэхээр ийм чөтгөрийн тойрогт орчихсон бол одоо яах вэ? Энэ компаниудыг мэдэж байгаа бол та хэлээч. Ямар арга хэмжээ авч байгаа юм. Эс үгүй бол мэдэхгүй байгаа юм уу? Ингээд ийм компаниуд байгаа гэдгийг Боловсролын сайд ярьчихлаа. Ер нь ийм гэмт хэргийн шинжтэй ийм компаниуд дээр ямар арга хэмжээ авдаг юм. Та хэд маань ер нь чадал тэнхээ байна уу? Арга хэмжээ авч чадаж байна уу? Хариуцлага тооцож чадаж байна уу?

Дараагийн асуудал энэ Аудитын тухай хууль дээр 4 дүгээр зүйлийн 4.1 дээр өөрчлөлт орох гэж.../минут дуусав.

Б.Бейсен: Жаргалсайхан гишүүнд нэг минут.

Д.Жаргалсайхан: Энэ дүгээр зүйлийн 4.1 дээр бас өөрчлөлт орох гэж л байна л даа. Энэ яах гэж байгаа юм? Бүүр та хэдийг маань ингээд хүчгүй болгох гэж байна уу? Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудыг шалгах эрхгүй болгох гэж байгаа юм уу? Энэ дээр нэмж хариулт өгөөч. Энд ямар хуулийн төсөл ороод ирэв? Ер нь би харахад бол Тогтвортой байдлын зөвлөл, манай энэ аудитын байгууллага тэгээд л ер нь л нэг хүчгүй болж хувирч байна уу? Ер нь та

хэдийг маань ер нь энэ манай энэ мафийн энэ сүлжээ ер нь ажлыг чинь хийлгэхгүй байна уу? Энэ дээр ямар байна. Ажлаа хийж чадаж байна уу та хэд гэсэн байдлаар хариулт өгөөч? Ер нь Монгол Улс маань ер нь дуусаж байна шүү дээ. Ер нь тэгээд л төсөв мөнгө нь ч гэсэн жил ирэх тусам нэмэгдээд л. Тэгээд үр дүн гардаггүй. Ахиц дэвшил байхгүй байна шүү дээ. Энэ улс оронд чинь ерөөсөө ард түмний амьдрал өдөр ирэх тусам ядуурч байна. Амьдрах нөхцөл боломжгүй болж байна шүү дээ. Энэ дээр нэг хариулт өгөөч. Та хэд маань ажлаа хийж чадаж байна уу? Тэгж өгөх боломж байна уу?

Б.Бейсен: Эхлээд Сангийн яам, дараа нь Аудитын газар.

Энэ төсвийн гүйцэтгэлд тайлан хэлэлцэж байгаа учраас сайдуудаа дуудахгүй бол болохгүй. Энэ гишүүд сайдуудаа ир гэж хэл. Тэгэхдээ засаг давхар хуралдаж байх шиг байна. Тэгэхдээ дундуур нь гарч ирээд зарим юман дээр хариулахгүй бол болохгүй юм шиг байна.

Сангийн яам 8 номер.

Б.Анар: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ урсгал зардал дээр хэтэрсэн гэж яриад байгаа юм. Урсгал зардлын хувь нийт зардалд эзэлж байгаа хувь 77 хувь болоод хэтэрчихсэн. 75 байсан байх ёстой байсанаас хэтэрчихсэн гээд. Энэ бол ямар нэгэн зөрчил биш гишүүн ээ. Яагаад гэхээр угаасаа урсгал зардал чинь 1.2 их наядаар зардлаа санхүүжүүлж чадаагүй байхгүй юу. Зардлыг нь санхүүжүүлээгүй гэсэн үг. Тэгэхээр угаасаа гүйцэтгэл чинь нийт улсын төсвийн нийт зарлагын төлөвлөгөө нь 22.6 их наяд байсан. Нийт гүйцэтгэлээрээ 20.4 их наяд гарсан. Энэ дотроосоо урсгал зардал нь 17.9 их наяд байж байгаад гүйцэтгэлээрээ 16.7 их наяд гарсан. Тэгэхээр угаасаа анх төлөвлөгдсөн төлөвлөгөөнөөсөө бага гарсан гэсэн үг. Урсгал зардал ч тэр, хөрөнгийн зардал ч тэр. Тэгээд нийт гарсан гүйцэтгэл дотроо хуваагаад үзэхээр урсгал зардлынх нь дүн арай жоохон өндөр болж л хувь нь харагдаад байгаа. Тэрнээс нийт батлагдсан дүнгээсээ ямар нэгэн байдлаар зөрсөн асуудал байхгүй гэдгийг танд хэлье.

Хоёрт тэр Боловсролын яаман дээр ингээд олон байгууллагууд тендерт шалгарчхаад төсөвт өртгөө нэмээд яваад байдаг гээд ийм асуудал яриад байгаа. Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулиар тухайн тендерт шалгараад ажлаа хийхгүй байгаа ААН-үүдийг процесс нь яаж явдаг вэ гэхээр тухайн захиалагч нь өөрөө эхлээд ажил авсан компани, ажил гүйцэтгэж байгаа компани нь энийг ажлаа гүйцэтгэхгүй байна энийг эхлээд энэ жагсаалт руу, хар жагсаалт руу оруулъя гэдэг хүсэлтийг Сангийн яам руу ирүүлэх ёстой.

Тэгж байж бид нар тухайн ААН-ийн гүйцэтгэл болохгүй байгаа, одоо хар жагсаалт руу оруулах ажлыг хийнэ. Тэр хүсэлт нь ирэхгүй бол одоо бид хэд шууд тэр ААН-ийг ажлаа гүйцэтгээгүй байна гэж дүгнээд оруулах бол боломжгүй болчихоод байгаа юм.

Хоёрт энэ батлагдсан төсвөөсөө хэтрээд төсөв нэмэгдээд байгаа асуудал юу байна вэ гээд үзэхээр өмнө нь бол нэлээн олон судалгаанууд хийгдсэн. Аудитын байгууллага ч энэ дээр дүгнэлт гаргаж байсан.

75 хувь нь энэ зураг төсөвтэй холбоотой асуудлаас болоод төсөвт өртөг хэтрээд байна гэдэг юм яригдаад байгаа юм. Тэгэхээр манай дээр хийгдээд байгаа энэ хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсвүүдийн чанар нь өөрөө шаардлага

хангахгүй байгаад байгаа асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бол мэдээж хариуцсан салбарын сайд нь Барилгын сайд энэ тухайлсан зураг төсвийн нор стандарттай тодорхой өөрчлөлт оруулах ийм шаардлага хангахгүй зураг төсөв хийгээд байгаа ААН-үүддээ тусгай зөвшөөрөлтэй нь холбоотой байдлаар хариуцлага тооцох ийм боломж байгаа. Энэ чиглэлээр бид нар холбогдох хүсэлтийг холбогдох яамдууд руу нь явуулж байгаа гэдгийг хэлье.

Татварын урьдчилгаа орлого авсан байна гэсэн ийм юм та хэлсэн. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн дагуу 28.1-д заасны дагуу татвар төлөгч нь төлбөл зохих татварын ноогдлоо өөрөө тодорхойлоод хуулиар тогтоосон хугацаандаа төсөвт төлөх үүрэг хүлээдэг. Нэмээд төлж болдог ийм л зохицуулалт байгаа. Тэрнээс урьдчилаад авсан гэсэн ийм юм бол байхгүй ээ.

Дээрээс нь ААНОАТ гүйцэтгэлээрээ угаасаа өнгөрсөн онд бол ААН импорттой холбоотой татварууд, импортын идэвхжилтэй холбоотойгоор тасарсан. ААНОАТ бол эдийн засгийн идэвхжил өөрөө сул байсан өнгөрсөн оны эхний 1 дүгээр хагаст бол одоо яг түүхий эдийн гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн экспорт унасан байсан. экспорт үндсэндээ эхний хагаст зогсонги байдалтай байсан. Үүнтэй хамааралтайгаар нийт эдийн засгийн идэвхжил сул байснаас хамаараад ААН-ийн орлогын албан татварын төвлөрөл гүйцэтгэл муу байсан гэдгийг хэлье.

Б.Бейсен: Гишүүдийн асуусан асуултад Төрийн нарийн бичгийн дарга нар энэ харьяа яамдын газрын дарга нар яг салбарынхаа хувьд тодорхой хариулах хэрэгтэй байна. Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Аудитын асуулт байгаа юм байна шүү дээ. Магнайсүрэн дарга.

Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Эхлээд энэ хуультай холбогдуулаад Жаргалсайхан гишүүн тодрууллаа. Одоо ингээд төрийн болон орон нутгийн өмчийн энэ нөгөө шинэ хууль ил тод байдал энэ бүтээмжийг сайжруулах энэ шинэ хууль дээр төрийн болон орон нутгийн өмчийн компанийн санхүүгийн тайлангийн аудитыг хийх тэр хувийн аудитын тусгай зөвшөөрөл бүхий хувийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ. Тэрийг нь болохоор тухайн компанийн тууз шалгаруулахаар ийм хуулийн заалт явж байгаа юм. Бид сүүлийн 2 өдөр энэ ажлын хэсэгтэй хамтарч ажиллаад энэ бол ингэж болохгүй.

Нэгдүгээрт бол энэ Үндсэн хуульд заагдсан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн энэ хяналтын чиг үүрэг. Ингээд компанийн засаглалын хэмжээнд ингэж шилжих ийм зарчим явах гэж байна. Энэ буруу шүү гэдэг дээр нэлээн ойлголт өгөөд.

Б.Бейсен: Магнайсүрэн дарга гүйцээж хариул 6 номер.

С.Магнайсүрэн: Тэгээд ажлын хэсэг дээрээ Сайнзориг гишүүн, Үүрийнтуяа гишүүн ахалсан ийм ажлын хэсэг дээр өчигдөр нэлээн ярилцаад зарчмын хувьдаа дахиж ярихаар өнөөдөр Байнгын хороогоор Эдийн засаг, Төсвийн байнгын хороо хамтраад хуралдчихаад салж хуралдах үед Байнгын хороогоор энд хуулийн төсөл орохоор байгаа. Энэний өмнө Үүрийнтуяа гишүүн орон нутагт ажиллаж байгаа өнөөдөр ирсэн байгаа ингээд уулзалдаад ингээд ойлголцоод явчих болов уу гэсэн нэг ийм зүгээр юутай байна. Урьдчилсан мэдээлэлтэй байгаа. Ер нь хэрвээ ингэх юм бол бид нар одоо өнөөдрийн 11 их наядын зөрчлийн 8.2 их наяд нь төрийн болон орон нутгийн өмчийн компанитай холбогдож байгаа юм. Тэгэхээр энэ зөрчилтэй энэ

хэсэг дээр бид нар ингээд онцгойлон анхаараад цаашдаа ажиллах ёстой байтал энэ хэсэг бидний хяналтаас гарна л гэсэн үг. Бидний хяналтаас гарна гэдэг бол Их Хурлын хяналтаас гарна л гэсэн үг.

Тийм учраас бид нар энэ дээр Их Хурлын гишүүдийг анхаарч мэдээлэл өгөх шаардлагатай болж байгаа. Байнгын хороон дээр бид нар энэ талаар нэлээн дэлгэрэнгүй тайлбарлана гэж ингэж бодож байгаа.

Хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг манай Энхболд дарга нэмээд хариулчихъя.

Б.Бейсен: 3 номерын микрофон.

Б.Энхболд: Үндэсний аудитын газар, Энхболд Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя аа. Төсөвт өртгийн нэмэгдэлтэй холбоотой асуудал дээр Үндэсний аудитын газраас Төсвийн байнгын хорооны тогтоол 2025 оны тогтоолыг үндэслээд 2 удаагийн аудитыг хийсэн байгаа. Төсөвт өртгийн нэмэгдэх болсон шалтгаан энэ дээр цаашид авах арга хэмжээний талаар энэ дээр 2 үндсэн шалтгаан байгаа. Нэгд нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээнүүдийг баталж хэрэгжүүлсэнтэй холбоотой хоёрт нь санхүүжилтийг зохистой түвшинд хуваарилал өгөөгүй удааширснаас болоод инфляцын бараа материалын үнийн инфляцтай холбоотой ийм нэмэгдлүүд гарсан үндэсний аудитын газраа гаргаж байгаа дүгнэлтийн хувьд магадлалыг хийсэн байгаа. Магадлалыг норм нормативын дагуу үнэн зөв тооцоолсон байна уу гэдэг дээр л хөндлөнгийн хяналт хийж байгаа.

Түүнээс тухайн төсөвт өртөг дээр Үндэсний аудитын газар аудит хийгээд нэмэгдсэн тохиолдол байхгүй ээ.

Б.Бейсен: 3 номер гүйцээж хариулъя.

Б.Энхболд: Тухайн аудитаар зураг төсвийн алдаа гаргасан олон компаниудаас энэ асуудал дээр бид нар компанийн жагсаалтыг Барилга, хот байгуулалт орон сууцжуулалтын яам болон Барилгын хөгжлийн төвд холбогдох арга хэмжээг авах албан шаардлагыг хүргүүлж ажилласан байгаа. Энэ жилийн хувьд энэ асуудал удаа дараа давтагдан гараад байгаа учраас энэ ажлыг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын тогтолцооны асуудал дээр одоо үндсэн шалтгаан байна аа. Бүтэц, зохион байгуулалт тогтолцооны асуудлыг нь суурь шалтгааныг гаргаж ирье гэдэг үүднээс 2026 онд тусгайлан Төсвийн байнгын хорооны сэдэв батлаад 3 хөгжлийн төв дээр тогтолцооны аудит хийхээр 9, 10 сард Төсвийн байнгын хороонд танилцуулагдахаар ингэж төлөвлөөд ажиллаж байна аа.

Б.Бейсен: Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Хэдүүлээ энэ хийсэн ажлаа нэг зөв сайн үнэлж дүгнээд ямар алдаа зөрчил гарав, цаашдаа яаж анхаарч ажиллах вэ гэдэг дээр бол сайн ярилцах ёстой. Тэгээд үнэхээр энэ гишүүд төрдөө итгэхээ больж байгаа юм уу, төрийн байгууллагадаа итгэхээ больж байгаа юм уу? Яагаад хувийн хэвшлээр төрийн оролцоотой энэ компаниудыг хяналт шалгалтыг хийлгэхээр аудит хийлгэхээр болов гэдэг асуудал ингээд та бүхэнд маань эргэлзээ төрж байгаа юм. Яг үнэндээ ний нуугүй хэлэхэд. Тэгээд энэний цаана ингээд төрийнх нь сайд нь хүртэл ийм асуудал яриад сууж байгаа юм.

Тэгэхээр яг энэ 3 байгууллага байгаа шүү дээ. Магадлан хийж байгаа 3 байгууллага байгаа. Энэ хүмүүст л асуудал байгаа шүү дээ. Тэрнээс тэр хувийн байгууллагыг ажлаа гүйцэтгээд ирсэн байна гээд төрийн тамга дараад гарын үсэг зурж байгаа юм. Гэтэл араас нь хэдүүлээ юу гэдэг юм тэр ААН-ийн буруу юм шиг яриад сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр төрдөө итгэх итгэлгүй болсон учраас л ийм хууль санаачлагдаж байна шүү дээ. Тэгэхээр та бүхэн маань үнэхээр энэ улс төрөөс хараат байж чадаж байна уу, ажлаа хийж чадаж байна уу?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 6 номер Магнайсүрэн дарга.

С.Магнайсүрэн: Үндэсний аудитын газар Магнайсүрэн Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Бид нар өнөөдрийн үйлчилж байгаа хууль, эрх зүйн орчны хүрээнд бүх боломжоо дайчлаад Улсын Их Хурал холбогдох Байнгын хороо дэд хороодтойгоо хамтраад ингээд ажиллаж байгаа. Ажлын үр дүнгүүд гарч байгаа. Өнгөрсөн жилээс зөрчлийн тоо хэмжээ бол 10 орчим хувиар буурсан ийм дүн мэдээтэй. Дээр нь аудитын шийдвэрийн хэрэгжилт дээр хууль, хяналтын байгууллагууд болоод бусад төсвийн ерөнхийлөн захирагч нар анхаараад эхэлсэн. Хэрэгжилтийн хувь сайжирч байгаа ийм үр дүнгүүд гараад эхэлсэн байгаа. Тэгээд саяын тэр хуультай холбогдуулаад энэ компанийн ТУЗ дээр л асуудлыг ингэж манайхаас нэр авч байгаад, манайхаас нэр авсан компаниудын дунд өөрсдөө тендер зарлаад өөрсдөө шалгаруулаад явна гэсэн нэг тийм зарчим явсан юм байна лээ.

Бид нар энийг бол Үндсэн хуульд харшлах хэмжээний ийм зарчим явах гээд байна гэдгээр тайлбар өгөөд.

Б.Бейсен: Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлантай танилцлаа. Төрийн аудитын байгууллага тэгээд энэ нөгөө Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хийсэн дүгнэлт, зөвлөмж, аудитын тайлантай нэг, нэггүй танилцлаа. Ер нь бол аудитын байгууллага нь ч ялгаагүй, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь ч ялгаагүй сүүлийн нэг жилийн туршид бол энэ санхүүгийн тайланд аудит хийж, дүн шинжилгээ хийх энэ байдал бол ер нь улам муудсан байна л гэж харахаар байна.

Төсөв нэмэгдэхийн хэрээр төсвөөс энэ татаасыг маш их олгож байна л даа. Бүх яамдууд өөрсдийн тодорхой хэмжээний маш их дүнгийн татаастай. Тэгэхээр энэ татаас гэдэг юмыг төсвөөс олгож байгаа энэ татаас гэдэг юм ер нь энийг яаж хязгаарлах юм бэ? Сангийн яам ер нь энэ олон олгож байгаа энэ төсвөөс олгож байгаа татаасуудад ямар шинжилгээ хийж, свот шинжилгээ хийж энэ татаасаар санхүүжүүлж байгаа төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагууд ААН-үүд тэгээд энэ олон яамдын гаргаж байгаа энэ татаасын дүн шинжилгээ хийж зарцуулалтад ямар хяналт тавьсан бэ? Энэ олон татаасаар олгосон санхүүжилтийн үр дүнд бий болсон нэмүү өртөг тэгээд үйлдвэрлэлийн эдийн засагт нөлөөлөх өсөлт ер нь хэдэн хувьтай байгаа юм бэ? Энийг нэг Сангийн яамнаас асууя. Ингээд хараад байхаар бол бүх яамдууд ер нь энэ тайлангаар гүйцэтгэл төсвийн гүйцэтгэл бол харьцангуй сайн өсөлттэй. Жишээ нь хүнс ХААЯ Эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө нь 2.6 хувьтай хувьтай Эрчим хүчний яам Эдийн засагт үзүүлэх нөлөө 2.2 хувь. Хэдийгээр салбарын байдал, санхүүгийн алдагдал санхүүгийн сахилга бат маш муу байгаа боловч өсөлт хэвээр өсөлт байгаад л байна. Тэгэхээр барилгын салбарт ч өсөлт байна. Цахим хөгжил инновацын салбарт ч байна. Гэр бүл

нийгмийн хамгааллын салбарт ч байна. Ер нь салбар бүрд өсөлт байна. Хамгийн онцгойлон хүнс, хөдөө аж ахуйн салбар маш тааруу байсан. Сая өнгөрсөн жилд өсөлттэй сайн өсөлттэй гарсан байна. Төсвийн гүйцэтгэл. Тэгээд эндээс харахад төрийн өмчит болон хувийн хэвшлийн байгууллагад олгож байгаа татаас төлөвлөснөөс гүйцэтгэл төрийн хэвшлийн.

Б.Бейсен: Батчимэг гишүүн нэг минут.

П.Батчимэг: Олгож байгаа татаас нь зөрөө нь үлдэгдэлтэй, нэлээн үлдэгдэлтэй хэвээр байна. Энэ яагаад олгогдоогүй үлдчихэв. Энийг нэг хэлээд өгөөрэй.

Үнэт цаасны юун дээр их том татаас олгосон байна л даа.

5 тэрбум төгрөгийн татаасыг Сангийн яам, ХХААХҮЯ хадгаламжийн даатгалын корпорац, Зээлийн батлан даалтын сангийн хооронд байгуулсан гэрээгээр үнэт цаасны худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх гэдэг үндэслэлээр 5 тэрбум төгрөгийн татаас олгожээ. Энэ татаас олгосон үндэслэл зарцуулалтын талаарх мэдээллийг Сангийн яамнаас авъя аа.

Б.Бейсен: Эхлээд Сангийн яам хариулъя. 8 номер.

Б.Анар: Батчимэг гишүүний асуултад хариулъя.

ХАА-н салбар нийт өнгөрсөн онд олгосон татаас бол нийт татаасыг ер нь 2 ангилд хуваагаад үзэж болно. Төрийн өмчит, төрийн өмчит байгууллагууд төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгож байгаа татаас. Энэ дотор нь бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол хамгийн өндөр дүн нь байдаг. Нийгмийн даатгалын сан руу энэ тэтгэвэр тэтгэмж олгохдоо зориулаад нийтдээ 1.1 их наяд 453 орчим тэрбум төгрөгийн татаас өгдөг.

Дээрээс нь эрчим хүчний сайдад бол энэ нөгөө төрийн өмчийн 14 ДЦС-уудтай холбоотой эрчим хүчний үнэ тарифын алдагдлын нөхөлт болгож 44.2 тэрбум төгрөг.

Дээрээс нь ийм төсвийн ерөнхийлөн захирагч нарт ийм татаасыг өгч байгаа. Хувийн хэвшлийн байгууллагуудад олгох татаас дотор энэ ХХААХҮ-ийн сайдад олгож байгаа татаас бол хамгийн өндөр дүнг эзэлж байгаа. Энэ дотроо яг батлагдсан төсөв бол 420.7 тэрбум төгрөг, гүйцэтгэл бол 197.1 тэрбум төгрөг гарсан байгаа. Энэ дотор бол энэ нөгөө хүнсний болон ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих зээл, Шинэ хоршоо, чинээлэг малчин, цагаан алт, Атрын 4 дүгээр аян, малчны зээл хойшлуулахад гээд ийм зээлүүд дээр татаасуудыг өгсөн.

Дээрээс нь нэмээд энэ ипотекийн зээлээр нөгөө дамжуулан олгож байгаа орон нутагт амьдарч байгаа иргэдэд олгох 3 хувийн хүүтэй зээлийн хүүгийн зөрөөн дээр 3 хувийн хүүгийн зөрөөн дээр татаас өгч байна. Дотоодын агаарын тээвэрлэгчдийг дэмжих зээлд гээд 4 банкаар дамжуулан 3 зээлдэгчдэд олгосон зээл дээр бас 2.4 тэрбум төгрөгийн татаас олгогдсон байна. Аялал жуулчлалыг салбарыг дэмжих зээлд 6 банкаар дамжуулаад 49 зээлдэгчид зээл олгосон. Энэний хүүгийн татаас.

Б.Бейсен: Гишүүдийн асуусан асуултад тодорхой хариу хэлмээр байх юм.

Б.Анар: Төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр тавиад очиж байгаа шууд зээлүүд шууд ААН-үүдийн зээл байдлаар очиж байгаа шүү дээ, хөнгөлөлттэй зээл байдлаар. Тэгэхээр энэ дээр орж байгаа нийт хамрагдсан ААН-үүдийн тоог тухайн салбарын яамдууд нь хариулах байх. Эдийн засгийн өсөлтийн хувьд та түрүүн хэлсэн. Эдийн засгийн өсөлт 6.8 хувьтай 2025 оны эцсээр гарсан. Энэ дотор бол мэдээж ХАА-н салбарын өсөлт 2.3 нэгж хувийг нь бүрдүүлж байгаа нь ХАА-н салбар.

Энэ өсөлтийг авчирч байгаа гол зүйл нь цаад талдаа юу байсан юм гэхээр энэ ХАА-н салбарт хэрэгжиж байгаа зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилт нь ААН-үүд рүү очиж байгаа энэ төсвөөр дамжаад энэ төсвийн сувгаар дамжаад очиж байгаа энэ хөнгөлөлттэй зээл татаас, урамшууллын хүрээнд энэ өсөлт бий болсон гэж үзэж байгаа юм.

Б.Бейсен: ХАА-нхан хариулъя. 9 номер. Дараа нь аудитынхан бэлдэж байгаарай.

Б.Бейсен: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга. Батлан даалтын сантай холбоотой гишүүний асуусан асуултад хариулъя.

2021 оны 42 дугаар тогтоолоор энэ ковидын үед нөгөө 10 их наядын хөтөлбөр гэж зарласан байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд 2 их наяд төгрөгийг бизнесийг дэмжих ААН-ийг дэмжих зээлд зориулж гаргасан. Энэн дээр болохоор Зээлийн батлан даалтын сан маань энэн дээр бол нөгөө барьцаа хөрөнгө хангахгүй байгаа энэ ААН-үүд дээр батлан даалт гаргах энэ зохицуулалтаар 2021 онд энэ тогтоол дээр орж ирсэн юм. Энэ тогтоолын 3 дугаар зүйлд болохоор тухайн үед төсвөөс батлан даалтын хөрөнгийг нэмэгдүүлж чадаагүйн улмаас Хадгаламжийн даатгалын корпорацаас 50 тэрбум төгрөгийг зээлээд энийг болохлоор жил болгон ХАА-н сайдын багцад Зээлийн батлан даалтын сан дээр 5, 5 тэрбумаар нь буцаж нөхөн төлүүлэхээр ийм зохицуулалт орсон байгаа.

Зээлийн батлан даалтын сан маань өөрөө Санхүүгийн зохицуулах хорооны хяналтад байдаг. Зохицуулах хорооны журмаар өөрийн хөрөнгийг 10 дахин нэмэгдүүлснээс илүүгээр.

Б.Бейсен: Энэ асуусан асуултад уг нь яамдын яг энэ ажил хариуцаж байгаа тайлан юутай холбоотой газрын дарга, шинжээчид, аудиторуудыг дуудаж байгаа шиг тодорхой хариулмаар байх юм. Одоо ХАА-н газар Болорчулуун дарга 9 номер.

Ц.Болорчулуун: Батчимэг гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгэхээр энэ хүнсний хувьсгал дээр өгсөн 1 тэрбум төгрөгийн зээлд жишээлбэл 8 ажлын байр шинээр тэгээд хүнсний нэр төрлийн бүтээгдэхүүний нэр төрөл 4.4-өөр, боловсруулах үйлдвэрийн хүчин чадал 294 тонноор, хүнсний үйлдвэрлэл 185 тонноор нэмэгдсэн ийм үр дүн гарч байгаа юм. 1 тэрбум төгрөгт аваад үзэхээр. Тэгэхээр энийг ингээд үржүүлээд үзэхээр ер нь хүнсний үйлдвэрт салбарт энэ хүнсний урсгалын хүрээнд олгосон зээл дээр түрүүчийн хэлсэнчлэн салбар болгоноороо тодорхой хэмжээний өсөлтүүд үр дүнгүүд гарсан байгаа.

Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд аваад үзэх юм бол.

Б.Бейсен: Болорчулуун даргад нэг минут нэмж өгье.

Ц.Болорчулуун: Хялгас ялгах хүчин чадал 530 тонноор, ээрэх хүчин чадал 300 тонноор, хивсний үйлдвэрлэл 0.2 сая м²-аар, сүлжих үйлдвэр 50 мянган ширхгээр, ширмэл эсгий 0.3 сая метрээр гээд ингээд бүтээгдэхүүн тус бүрээр үйлдвэрлэлийн сүлжээ бүрэн дээр ингээд тодорхой хэмжээний өсөлтүүд гарчихсан байгаа. Тэгэхээр энэ хөтөлбөрүүд дээр олгож байгаа зээлийн үр дүнгүүд, дээрээс нь хүнсний хувьсгалынх. Одоо ингээд 2 жилд барилга байгууламж тоног төхөөрөмжийн шинэчлэл дуусаж байгаа учраас энэ ирэх жилүүдэд тодорхой үр дүнгүүд нэмэгдэхээр байгаа гэдгийг танд хэлье ээ.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 6 номер Магнайсүрэн дарга.

Татаастай холбоотой асуудлаар бид нар бол тайлан дээрээ тусгачихсан гишүүд танилцчихсан байгаа. Зарим асуудлыг тусгайлан сэдвээр Төсвийн байнгын хороо жишээлбэл үнэ тогтворжуулах зорилгоор олгосон төрөөс олгосон татаасын асуудлаар сэдэв баталж өгсөн.

Энэ сэдвээр хийсэн тайланг өнөөдөр яг өнөөдөр Төсвийн байнгын хороон дээр одоо энэ 11 цагаас ярихаар ингээд юу яачихсан байж байгаа, нөгөө нууцын асуудалтай учраас хаалттай горимоор хэлэлцэхээр ийм байж байгаа. Энэ талаараа бид нар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө өө гишүүдэд.

Б.Бейсен: Нэг минут нэг минут Батчимэг гишүүнд.

П.Батчимэг: Улсын нэгдсэн төсөв, тэгээд энэ 2025 оны төсвийн гүйцэтгэл тэгээд санхүүгийн тайлан ярьж байгаа энэ асуудал үнэхээрийн том асуудал л даа. Тэгээд Хүнс, хөдөө аж ахуйн сайд, ТНБД нь байдаг юм уу үгүй юу? Болорчулуун гээд ганц газрын дарга л өдөр болгон энүүгээр л байнга хурал болгон дээр л сууж хариулт өгдөг.

Аудит болон төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг би сая шүүмжилж байгаа нь бол зүгээр шүүн хэлж байгаа ч үг биш л дээ. Ер нь 2024 онд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргаж өгсөн зөвлөмж буюу дүгнэлт, тэнд аудит дүн шинжилгээ хийж аудитын төрийн аудитаас оруулж ирж байсан 2024 оныхтой харьцуулахад одоо оруулж ирж байгаа материал нь ерөнхийлсөн тийм дүгнэлт л оруулж ирж байгаа юм. Зөндөө уншлаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 онд Санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Үг хэлэх гишүүд Мандхай гишүүнээр тасалъя. Мандхай гишүүн үг хэлье.

М.Мандхай: Ер нь бол энэ 2025 оны төсвийн гүйцэтгэлийг харахад нэлээн том асуудал нь өөрөө мөнгө ер нь хүрэлцээгүйдээ ч юм уу төсөв хангалтгүй байсандаа ерөөсөө биш. Баталсан төсвөө хэрэгжүүлж чадаагүйд хамгийн том асуудал байгаа юм аа. Тэгээд бид нар цаашдаа 2026 оны төсвийн гүйцэтгэл дээрээс нь 2027 оны төсвийн төлөвлөгөө, 2027, 2028 оны төсвийн хүрээ гээд бид нар ярьж байгаа энэ нөхцөл байдал дээр ийм хангалтгүй төсвөө хэрэгжүүлж чадаагүйд бол цааш цаашдаа яах вэ гэдэг асуудлыг бид нар ярих шаардлагатай байх аа. Тэгээд энэ олон яам байгууллага төлөвлөсөн энэ санхүүжилтээ авч ашиглаагүй, Сангийн яам нь санхүүжилтийг нь ерөөсөө тэр хаасандаа ерөөсөө биш.

Төсвийн ерөнхийлөн захирагчид өөрсдөө санхүүжилтийнхээ энэ хүсэлтийг гаргаагүй, төслөө хэрэгжүүлж чадаагүй нэг ийм энэ ингээд ер нь сонсоод байхад ер нь бол энэ системийн бүүр доголдол үүсчихсэн юм биш үү гэдэг дээр дүгнэж хэлмээр байгаад байгаа юм.

Тэгээд энэ ХАА-н салбар дээр би өөрөө ярьдаг хүний хувьд би дахиад хөдөө аж ахуй руугаа орох гээд байгаа юм л даа. Энэ хүнсний хувьсгал одоо ишээлбэл энэ үндэсний хөдөлгөөний зорилго нь 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангана гээд ийм том зорилго тавьчихсан. Гэтэл ингээд хэмжих KPI үзүүлэлтээ өөрсдөө тодорхойлж хариулж чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Үгүй 8 ажлын байр бий болгох гэж байгаа юм уу. 1.2 их наяд төгрөгийн мөнгө зарцуулчихаад 8 ажлын байр бий болгосон. 250 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн гээд ийм юм яриад суугаад байх юм. 19 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэсэн зорилго тавьчихаад мянгаад төрлийн бүтээгдэхүүн гаргаад байна гэнэ. Өөрсдөө ямар ч гүйцэтгэлийнхээ KPI үзүүлэлтийнхээ хэмжих үзүүлэлтээ ойлгохгүй явж байгаа байхгүй юу. Хэмжих ер нь үзүүлэлт нь байхгүй юм байна.

Тэгэхээр энэ Сангийн яам энэ дээр анхаар л даа. Энэ яамдаас өгч байгаа төлөвлөгөө гүйцэтгэл дээр нь яг хэмжих үзүүлэлт нь юу юм? Энэ төсвийн тогтвортой байдал энэ дээр хариулт авмаар байна. Энэ дээр юу гэж харж байгаа юм. Мэдэхгүй хүмүүс нь тэгвэл болохгүй бол энэ дээр болохгүй байна. Энэ KPI үзүүлэлт чинь биш байна гээд буцааж болдоггүй юм уу? Ийм юман дээр бид нар ингээд хэлэлцээд ингээд асуудлыг нь гүйцэтгэлийг нь хянаад асуулт асуугаад суухаасаа ч бүр үнэхээр хэлэх үг алга аа. Энэ дээр би Тогтвортой байдлын зөвлөлөөс ер нь цаашдаа энэ дахиад төсвийн гүйцэтгэлийн асуудлыг би бусад Байнгын хороон дээр ирэхэд нь хариулт авъя аа.

Одоо Эдийн засгийн байнгын хороон дээр та бүхэн орох байх. Ер нь энэ гүйцэтгэл дээр энэ хариулаад байгааг юу гэж харж дүгнэж байгаа юм бэ? Маш хангалтгүй байна л гэж хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр 2026 оны гүйцэтгэл 2027 оны төлөвлөгөөн дээр бид нар цааш цаашдаа ийм системийн доголдлыг засаж явахгүй бол энэ улс орны чинь үндсэндээ орлого, ажилгүйдэл, ядуурлын байдал орон нутагт маш хэцүү байгаа шүү. Энэ дээр холбогдох тэр бодлого хариуцаж байгаа яамдууд нь өөрсдөө анхаарч ажиллахгүй бол ер нь энэ улс орны хөгжил маш хэцүү байдалд орлоо л гэж би хэлмээр байна.

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн гүйцэтгэлд санхүүгийн нэгдсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулна аа.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

11.33 цаг

Дараагийн асуудалд оръё.

Шинжээч томилох тухай байныг хорооны тогтоолын төсөл.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Мандхай гишүүн горимын санал гаргах юм байна.

М.Мандхай: Байнгын хорооны дарга аа энэ тов дараалалд орсон 3 дахь асуудалтай холбоотой асуултыг би хаалттайгаар явуулах хүсэлт гаргаж байна. Горимын санал гаргаж байна.

Б.Бейсен: Гишүүдээ дуудаарай горимын саналаар санал хураалт явуулна аа.

Хажуу талын нөгөө юун дээр байгаа шүү дээ манайхан дуудаарай. Сонсгол руу гүйгээд.

Горимын саналаар санал хураалт явуулна.

Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтад бэлдээрэй.

Мандхай гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдээрэй гишүүд ээ.

Мандхай гишүүний горимын санал хаалттай явуулъя гэсэн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Ганхүлэг горимын санал гаргая.

М.Ганхүлэг: Санал хураалтыг дахин явуулж өгнө үү төхөөрөмж ажиллахгүй байгаад байна. Одоогоор орохгүй байгаад байна, танихгүй байгаад байна.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүний горимын саналаар саяын саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хүчингүй болгох санал хураалт 52.9 хувиар дэмжигдлээ.

Одоо Мандхай гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хаалттай явуулъя гэсэн Мандхай гишүүний горимын санал 52.9 хувиар дэмжигдсэн учраас хуралдааныг хаалттай явуулъя.

Хаалттай хэлбэрт шилжээрэй.

ХААЛТТАЙ

Дараагийн асуудалд оръё.

Гурав.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулна. Гишүүдээ дуудаарай. Болормаа гишүүнийг дуудаач. Болормаа гишүүнээ дуудаарай.

Ажлын хэсгээ оруул. Болормаа гишүүн хурал давхцаж байгаа юм байна. Ирэх хүртэл энэ ажлын хэсгийг танилцуулчихъя. Ч.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ц.Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон хөгжлийн бодлогын хэлтсийн дарга ирсэн байна. Х.Мөнхзул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга, ирсэн байна. Х.Номин Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүү зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн ахлах шинжээч ирсэн байна. Ц.Мөнхбат Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТХГН-ийн бодлогын газрын ахлах шинжээч ирсэн байна. А.Нарангарав Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч ирсэн байна. Ирсэн байна. Б.Номун НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй Нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх төслийн хуулийн зөвлөх ирсэн байна. Ирсэн байна.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдэх талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа танилцуулна. Болормаа гишүүнд микрофон өгье.

Э.Болормаа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдааны хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үеэр хуралдаан даргалагчаас хуулийн төслийн зарим хэсэг заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 263 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг чиглэл өгсөн 5 асуудлаар 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж асуудал бүрийг нэг бүрчлэн хэлэлцэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу бэлтгэн томьёолж дараах саналыг Байнгын хороонд танилцуулж байна аа.

1.Хуулийн нэр томьёоны тодорхойлолтын үг хэллэг найруулгыг энгийн ойлгомжтой байдлаар жигдлэн томьёолж Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийг эшилсэн хэсэг заалтыг хасаж, зарим нэр томьёоны тодорхойлолтыг хуульд хэрэглэгдэх давтамж, агуулгаар нь эрэмбэлэн, хуулийн төслөөс хасах.

2. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар салбар хоорондын уялдааг хангах зорилгоор Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хороог байгуулах, тус хорооны санал зөвлөмжийг үндэслэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг батлах.

3. Үндэсний зохицуулагч байгууллага сааруулалтын үр дүнг тооцон шилжүүлэх байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнгийн тодорхой хувийг эрсдэлийн санд нөөцлөн энэ хуульд заасан журмын дагуу буцаан олгох, удирдлага хяналтыг хэрэгжүүлэх.

4. Иргэн хуулийн этгээдийн дасан зохицох даван туулах чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг жил бүр төлөвлөн санхүүжүүлэх зохицуулалтыг хуулийн төслөөс хасах саналыг гаргаж байна аа.

Мөн ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэнтэй холбогдуулан тогтоолын төслийг боловсрууллаа.

Уг тогтоолын төсөлд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Эрчим хүч, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, зам тээвэр, барилга, хог хаягдал зэрэг салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, зорь зорилттой уялдуулан хэрэгжүүлэх. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний платформыг уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн сан, карбоны бүртгэл, хүлэмжийн хийн үндэсний тооллогын мэдээллийн системтэй холбон иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллага, төсөл хөтөлбөр, хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл солилцох, бүртгэл хөтлөх, тайлагнах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх, боловсролын сургалтын байгууллага, уур амьсгал өөрчлөлтийн талаар олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа хийх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн талаар авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийн тайланг Улсын Их Хуралд танилцуулах зэрэг асуудлыг тусгалаа.

Ажлын хэсэг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд тараасан болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд

нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй санал, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Болормаа гишүүнд баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Санал хураалт явуулна гишүүдээ дуудаарай. Энэ хажуу талын Малчны тухай хуулийн хэлэлцүүлэгт байж байна дуудаарай.

Хоёр ажил давхацчихаад. Хажуу талд нэлээн олон гишүүн байх шиг байна.

Мандхай гишүүн яагаад гараад явчхав.

Жаргалсайхан гишүүн, Амгаланбаатар гишүүн 2-ыг дуудаарай. Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу 6 санал хураана. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг, 4.1.3 дахь заалтын “нэг ижил” гэснийг, 4.1.5 дахь заалтын “, болон сайн дурын санаачилгыг хэрэгжүүлэх” гэснийг, 4.1.12 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу” гэснийг, 4.1.13 дахь заалтыг, 4.1.15 дахь заалтын “зорилгоор ашигладаг” гэснийг, 4.1.16 дахь заалтыг, 4.1.21 дэх заалтын “замаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах бодлого,” гэснийг, 4.1.25, 4.1.27 дахь заалтыг, 4.1.30 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд” гэснийг, мөн заалтын “тохируулга хийж” гэснийг тус тус хасаж, 4.1.3 дахь заалтын “шингээлт эсхүл” гэснийг “шингээх үйл ажиллагаанаас үүссэн” гэж, 4.1.4 дэх заалтын “тогтвортой” гэснийг “арга хэмжээ,” гэж, 4.1.6 дахь заалтын “зах зээлийн тогтолцоог” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.14 дэх заалтын “шингээсэн” гэснийг “хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлсэн” гэж, 4.1.15 дахь заалтын “шаардлагаас” гэснийг “үүргээс” гэж, 4.1.28 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж тус тус өөрчилж, 4.1.6 дахь заалтын “худалдах,” гэсний дараа “арилжих, дүйцүүлэх,” гэж, 4.1.20 дахь заалтын “үйлдвэрлэл,” гэсний дараа “үйлчилгээ,” гэж, 4.1.28 дахь заалтын “зохицох” гэсний дараа “, даван туулах” гэж, 4.1.30 дахь заалтын “нэмж” гэсний дараа “, эсхүл хасаж” гэж, 4.1.32 дахь заалтын “бусад хийг” гэсний өмнө “олон улсын гэрээ, стандартаар хүлэмжийн хий гэж хүлээн зөвшөөрөгдсөн” гэж, 4.1.33 дахь заалтын “ой,” гэсний дараа “бэлчээр,” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, С.Ганбаатар, П.Наранбаяр, С.Одонтуяа, П.Сайнзориг, Ч.Ундррам, С.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/.

Санал хураалт.

78.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.8, 4.1.10, 4.1.11, 4.1.18, 4.1.19, 4.1.22, 4.1.24, 4.1.26, 4.1.31, 4.1.36, 4.1.37, 4.1.38, 4.1.39 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“даван туулах” гэж уур амьсгалын өөрчлөлт, аюулт үзэгдэл тулгарахад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтолцоо, үндсэн чиг үүрэг, өвөрмөц чанар, бүтцээ хадгалан хариу үйлдэл үзүүлэх, сэргээн зохион байгуулагдах, дасан зохицох чадавхыг;

4.1.7.“карбон кредит” гэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжтойгоор баталгаажсан, бүртгэгдсэн карбон нэгжийг;

4.1.8.“карбон нэгж” гэж сааруулалтын үр дүнг нэг тонн нүүрстөрөгчийн давхар ислийн тэнцэлд дүйцэх байдлаар илэрхийлсэн тооцооллын нэгжийг;

4.1.10.“ногоон таксономи” гэж байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн зорилтод хувь нэмэр оруулах эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг тодорхойлсон нэгдсэн шалгуур, ангиллыг;

4.1.11.“олон талт карбон зах зээл” гэж олон улсын гэрээ, шийдвэрийн хүрээнд төвлөрсөн зохицуулалтаар хэрэгжих, олон улсад шилжүүлэн тооцох, сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.18.“уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн агаар мандлын хийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс үүдэн уур амьсгалд урт хугацаанд гарч буй өөрчлөлтийг;

4.1.19.“уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий хүн амын бүлэг” гэж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, газар зүйн байршлын улмаас түүнд дасан зохицох, даван туулах чадавх хязгаарлагдмал хүн амын бүлгийг;

4.1.22.“уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл” гэж уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг өөрчлөлтийг;

4.1.24.“уур амьсгалын санхүүжилт” гэж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг;

4.1.26. “үндэсний карбон зах зээл” гэж үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд үүссэн карбон кредитийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах замаар зохицуулсан зах зээлийг;

4.1.31. “хоёр талт карбон зах зээл” гэж улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.36. “хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх” гэж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй тохиолдолд үүсэх байсан хүлэмжийн хийн ялгарлаас зайлсхийхэд чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.37. “хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах” гэж хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.38. “хүлэмжийн хийн ялгарлын тэнцэл” гэж тайлант хугацаанд үүссэн хүлэмжийн хийн нийт ялгарлаас бууруулалт, урьдчилан сэргийлсэн ялгарал болон шингээлтийг хасан гарах цэвэр дүнг;

4.1.39. “хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнг батлагдсан аргачлалын дагуу хэмжих, үр дүнг тайлагнах, тайлагнасан мэдээллийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн этгээдээр шалгуулан баталгаажуулах үйл ажиллагааг;

Санал хууралт.

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “хөтөлбөрийг тодорхойлсон” гэснийг “хөтөлбөрт зориулсан” гэж, 7.1.9 дэх заалтын “санхүүжилтийн орлогын урсгалыг” гэснийг “санхүүжилтийг” гэж, 7.1.10 дахь заалтын “ажиллагааг удирдах зохицуулах” гэснийг “ажиллагааны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “энэ хуульд заасан асуудлаар” гэснийг, 7.1.8 дахь заалтын “хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээлтийн үр дүнг тооцох, баталгаажуулах, тайлагнахтай холбоотой” гэснийг, 7.1.9 дэх заалтын “ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгал, үр ашиг, зарцуулалтыг бүртгэх, хянах, тайлагнах, цаашдын төлөвлөлтийг хангах, олон улсын тайлагнал болон ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой” гэснийг, 7.1.10 дахь заалтын “энэ хуулийн 4.1.27-д заасан” гэснийг, 7.1.11 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.1.1, 7.1.2 дахь заалт болгох:

“7.1.1.уур амьсгалын өөрчлөлтийн төлөвлөлт, хэрэгжилтийн салбар хоорондын уялдааг хангах зорилгоор Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хороог байгуулж, ажиллуулах;

7.1.2.Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны санал, зөвлөмжийг үндэслэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг батлах;”

Санал хураалт явуулъя.

68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “уур амьсгалын” гэсний дараа “өөрчлөлтийн” гэж нэмж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн хүрээнд” гэснийг “ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн” гэж, 11.1.2 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, мөн заалтын “хариуцсан зохио байгууллагад” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар” гэж, 11.1.3 дахь заалтын “удирдах” гэснийг “удирдлага, зохион байгуулалтаар хангах” гэж тус тус өөрчилж, 11.1.6 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэн” гэснийг, 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, 11.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.9.сааруулалтын үр дүнгийн урт хугацааны хадгалалт алдагдах, хэтрүүлэн тооцож шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнгийн тодорхой хувийг эрсдэлийн санд нөөцлөн, энэ хуулийн 7.1.7-д заасан журмын дагуу буцаан олгох, удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх;”

Санал хураалт.

78.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгана.” гэснийг хасах.

Санал хураалт

78.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 16.1, 16.4, 16.6 дахь хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 12.1, 12.2-т заасан үнэлгээний үр дүнд үндэслэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

16.4.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 4.1.19, 4.1.20-д заасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар, хүн амын бүлгийн дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

16.6.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.”

Санал хураалт.

78.9 хувиар санал дэмжигдлээ.

Санал хурааж дууслаа.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуул дууслаа.

Төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Болормаа чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

12.18 цаг

Дараагийн асуудалд оръё.

Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, **анхны хэлэлцүүлэг**/

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан байгаа. Энэ ажлын хэсэг хэвээрээ. Түрүүн энэ асуудлыг Болормаа гишүүн танилцуулчихсан байгаа.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Одонтуяа гишүүн горимын санал гаргая. Одонтуяа гишүүнмй микрофон өгье.

С.Одонтуяа: Баярлалаа. Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас энийг анхны хэлэлцүүлгээр нь баталж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Б.Бейсен: Тогтоолын төсөл дээр асуулт асуух гишүүд байхгүй учраас Одонтуяа гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураая даа. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Санал хураалт.

Тогтоолын төсөл 68.4 хувиар дэмжигдлээ. Мандхай гишүүнийг дэмжсэнээр авъя. Одонтуяа гишүүний горимын санал дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын

хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганд Одонтуяа гишүүн танилцуулна аа. Одоо нэг асуудлаа гишүүд тэвчээртэй яачхаарай.

12.20 цаг

Дараагийн хэлэлцэх асуудалд орёё.

Тав. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүн 2025.11.07-ны өдөр өргөн мэдүүлсэн/

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Ажлын хэсэгт баярлалаа.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү танилцуулна. 6 номер Баатархүү гишүүн танилцуулъя.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье ээ.

2025 оны 11 сарын 7-ны өдөр Улсын Их Хурлын даргад нийслэл Улаанбаатар хотын газар олголтын нөхцөл байдал дээр Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо байгуулж нэгдсэн дүгнэлт гаргах тогтоолын төсөл хянан шалгах түр хороо байгуулах шаардлага үндэслэлийг өргөн барьсан.

Тогтоолын төсөл өргөн барьсантай холбогдуулаад бүрдэл буюу улс төрийн намын бүлгүүд Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны хуулийн дагуу нэрсийг бүрэн өгч өнөөдөр дууссан. Ийм учраас харьяалагдах Байнгын хороогоор хэлэлцэгдэж байна.

Улаанбаатар хотод нийт иргэдийн маань 10 орчим хувь нь газраа өмчилж авсан. Улаанбаатар хотын энэ аж ахуйн нэгж, иргэд газраа ашиглах, эзэмших, өмчлөх энэ эрх зүйтэй холбоотой энэ харилцааг хуулиар зохицуулж байгаа. Энэ хууль хэрэгжиж байна уу гэдэг дээр хянан шалгаж цаашдаа Улсын Их Хурлын тогтоол гаргаж хууль тогтоомжид ямар өөрчлөлт оруулах юм бэ гэдэг ийм дүгнэлт гаргах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны төслийг өргөн барьж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд дэмжих юм бол Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр энэ хянан шалгах түр хороог байгуулах эсэх асуудлаар тогтоолын төсөл гарна аа.

Нэгдүгээрт бол Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг Улаанбаатар хотын газар олголтын шийдвэр, газар ашиглалтын байдал, гарсан алдаа зөрчил, газар ашиглалтын үр дагаварт бий болсон нийтийн эрх эрх ашигт харшлах асуудлыг тодорхойлох зорилгоор холбогдох тогтоол шийдвэр газар олголтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гэдэг ийм зорилгыг тусгасан.

Хоёрдугаар заалтаар бол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээг тодорхойлж өгсөн.

Гуравдугаарт бол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг мөн хавсралтаар тусгасан.

Байнгын хорооны референтүүд дээр улс төрийн нам, бүлэг эвсэл, зөвлөлөөс бол гишүүдийн нэрс ирж бүрдэл хангагдсан байгаа.

Дөрөвдүгээрт бол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороонд гаргасан тайлан санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулахыг Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороонд даалгасан ийм 4 зүйл заалттай Хянан шалгах түр хорооны удирдамж бүрдүүлбэрийг бүрдүүлсэн байна аа.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс асуух асуултад хариулахад бэлэн байна. Улсын Их Хурлын 35 гишүүн нэр бүхий 35 гишүүн Хянан шалгах түр хороог дэмжиж гарын үсгээ зурсан байна гэдгийг та бүхэндээ танилцуулъя. Баярлалаа.

Б.Бейсен: Баатархүү гишүүнд баярлалаа.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Энэ Улсын Их Хурал дахь намын бүлгүүд ХҮН Намын зөвлөлийн юуг ирүүлчихсэн байгаа. Энэ АН-аас Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд оруулах тухай улсуудын нэр явуулсан байна. Ц.Баатархүү, П.Батчимэг, Ч.Лодойсамбуу, Ө.Шижир нарын нэрийг өгсөн байна. Ардын намаас Хянан Шалгах Түр хорооны бүрэлдэхүүнд оруулах тухай Монгол Улсын Их Хурлын гишүүн Заяабал, Нанзадын Наранбаатар, Зулпхар, Энхцэцэг, Бадамсүрэн, Мандхай, Уянга, Отгонбаяр нарыг оруулах саналыг хүргүүлсэн байна. Иргэний Зориг ногоон намын зөвлөлөөс Нарантуяа-Нарагийн нэрийг өгсөн байна. Батбаатар дарга.

Энэ Хүн намын зөвлөлөөс Улсын Их Хурлын гишүүн Пүрэвсүрэнгийн Наранбаярын нэрийг өгсөн байна.

Үндэсний Үндэсний эвслээс хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн М.Сарнайг оруулах саналтай байна гэсэн байна аа. Энэ бүх намын зөвлөлөөс энэ улсад ашиг сонирхлын ямар ч зөрчилгүй гэсэн дүгнэлт гаргасан байна.

Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Жаргалсайхан гишүүн горимын санал гаргаж байна. Жаргалсайхан гишүүний микрофон.

Д.Жаргалсайхан: Ингээд энэ сонсгол хийх энэ ажлын хэсэгт хүний нэр нэммээр байна аа. Гишүүдийн тоо арай цөөхөн байна. Тийм учраас бүгд бүрдчихсэн үү санал гаргах боломжгүй юу?

Б.Бейсен: Баатархүү гишүүн 6 номер.

Ц.Баатархүү: Эрхэм Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Зүгээр энэ Улсын Их Хурлын хянан шалгах тухай хууль дээр түр хороо байгуулах нам эвслүүдийн бүлгийг ингээд сондгой тоотой нэрээ өгсөн байгаа. Зүгээр референтүүд энэ дээр нэг тайлбарлаж өгөөч гэж бодож байна. АН-ын бүлгээс бол 4 гишүүний нэр өгөөд олонхын бүлэг 5 нэр өгөх учиртай, олонхын бүлэг. Тэгээд нам эвслийн бүлгүүдээс нэр аваад өөрөөр хэлэх юм бол хуулийн хууль дээр тодорхой заалт нь бол олонх бүрдүүлж байгаа нам нь арай илүү олон гишүүний нэр өгөх юм байна лээ. Тэгэхээр энэ заалт хангагдаж байгаа юм уу? Одоо энэ байгуулагдаж байгаа Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн чинь нийт яг хэдэн хүнтэй болчихож байгаа юм бэ? МАН-аас яг хэдэн хүний нэр ирсэн юм бэ гэдэг дээр тодорхой энэ мэдээллийг дахиж өгөөч гэдэг ийм хүсэлт гаргаж байна аа.

Б.Бейсен: Энэ олонхыг төлөөлөн Бадамсүрэн, Заяабал, Зулпхар Мандхай, Наранбаатар, Отгонбаяр, Уянга, Энхцэцэг гээд байж байна.

Тэгэхээр чинь энэ чинь 8 хүн байна. Цөөнхийн төлөөлөл Баатархүү, Батчимэг, Лодойсамбуу, Нарантуяа-Нара, Наранбаяр, Сарнай, Шижир гээд ингээд 7 хүн байна. 8, 7-ийн харьцаатай юм байна. Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Тэгье одоохон нэг протоколд тэмдэглүүлье.

Хянан шалгах түр хорооны санал хураахаас өмнө нэг горимын саналыг дэмжүүлэх шаардлага байна. Энэ Хянан шалгах хорооны хамрах хүрээг төслийг санаачилж байгаа 35 гарын үсэг зурсан тал Байнгын хорооны хурал дээр нэмж болох ийм заалттай. Тийм учраас би энэ хамрах хүрээг нэмэгдүүлэх ийм саналыг оруулж байна. Тэгэхээр энэ дээр бол Байнгын хороогоор санал оруулна. Референтүүд маань яг хуулийн энэ заалт болж байна болохгүй байна гээд ерөөсөө хариулахгүй нэг их сонин байдалтай байгаад байна. Энэ асуудал дээр яагаад нэг ийм юу байна аа? Манайхан бүгдээрээ ингээд хуулиа яриад явмаар байна.

Нэгдүгээрт энэ нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга болон холбогдох захиргааны байгууллагын гаргасан газар олголттой холбоотой 1992-2025 оны шийдвэрүүд.

2.Газрын тухай хуулийн хэрэгжилт, газрын өмчлөл эзэмшил, ашиглалтыг зориулалтаар олгосон байдал.

3.Нийтийн эзэмшлийн газар ногоон байгууламж.

Тэгээд би энэ санал дээрээ энэ Богд уулын тусгай хамгаалалтад олгосон газар олголтыг мөн хянан шалгах гэсэн энэ хамрах хүрээг оруулж байна. Энэ дээр санал оруулж өгөөч гэдэг хүсэлт байна.

Б.Бейсен: Ер нь наад саналыг байна шүү дээ дахиж байнгын хороо руу орох учраас тогтоолын төслийг тараачихсан учраас наадхыг чинь дараа ажлын хэсэг байгуулсны дараа ажлын хэсгийнхэн санал оруулж болно.

Одоо шууд санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Хянан шалгах түр

хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ, хязгаар Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Санал хураалт бэлдэж дууссан уу?

Санал хураалт.

Санал 52.6 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүд ажлаа хийсэнхэнд баярлалаа.

12.33 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА